4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	184,694,752.97
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	177,445,222.58
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	91	91
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
610001	Төсвийн байгууллага	5	5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43	43
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13
620003	Үйлчлэх ажилтан	22	22
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43	43
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26	26
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,575,042.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,575,042.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,383,311.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,329,471.42
210301	Гэрэл, цахилгаан	584,511.42
210303	Цэвэр, бохир ус	9,744,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	953,840.00
210402	Тээвэр, шатахуун	913,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00
210602	Тавилга	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,950,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,191,731.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	499,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	499,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,692,731.46
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	26,408,420.88
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	284,310.58
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,166,622.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,166,622.00
131103	ЗГНХ, ЗДНХ өрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,635,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,531,522.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-26,408,420.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,408,420.88

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг дарга нь “Нутгийн онцлогт тохирсон уламжлалт МАА,газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, орон нутгийн нөөц,боломжид тулгуурласан ЖДҮ-лэл хөгжүүлж сумын эдийн засгийн өсөлтийг хангасан, иргэдийн оролцоонд тулгуурлан ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалсан. чанартай,хүртээмжтэй үйлчилгээг иргэдэд хүргэж хүний хөгжлийг дээдэлсэн сум болно.” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,429.4 сая төгрөгөөр буюу 64.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	566.0	521.1	-44.9
Авллага	195.0	165.8	-29.2

Бараа материал	267.2	67.0	-200.2
Үндсэн хөрөнгө	5850.9	1695.8	-4,155.1
Нийт хөрөнгө	6,879.1	2,449.7	- 4,429.4
Өр төлбөр	117.9	96.0	-21.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,761.2	2,353.7	-4,407.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,879.1	2,449.7	- 4,429.4

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 44.9 сая төгрөгөөр буурсан нь ОНХС-ийн өмнөх онд хийгдэх худалдан авалтын ажил хийгдсэн байна.
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 29.2 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлснээр 117.7 сая төгрөгөөр буурсан, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 80.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид санхүүгийн тайланг нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 521.1 сая төгрөг болж, өмнөх оноос 44.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	8.1	2.6	-5.5
Төгрөг	8.1	2.6	-5.5
Төрийн сангийн харилцах	567.9	518.5	-39.4
Дүн	566.0	521.1	-44.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 521.1 сая төгрөгийн 518.5 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 2.6 сая төгрөг байгууллагын ОНӨААТҮГ-ын харилцах дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 75.3 сая төгрөг буюу 2.9 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 102.1 сая төгрөг буюу 19.5 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 341.1 сая төгрөг буюу 64.4 хувь төрийн сангийн харилцахын зарцуулагдаагүй үлдэгдэл тус тус эзэлж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 165.8 сая төгрөг болж, өмнөх оноос 29.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	117.7	-	-117.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	3.0	16.0	13.0
Байгууллагаас авах авлага	7.4	2.0	-5.4
Хувь хүмүүсээс авах авлага	66.9	147.8	80.9

Дүн	195.0	165.8	-29.2
-----	-------	-------	-------

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 147.8 сая, ЗДТГ-ын 1.2 сая төгрөгийн гүйлгээг хоршоо хөгжүүлэх сангаас авах, Халзан дулаан ОНӨААҮГ-ын халаалтын авлага 15.9 сая төгрөг байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 67.0 сая төгрөг болж, өмнөх оноос 200.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	39.5	24.6	-14.9
Тусгай зориулалттай материал	14.4	0	-14.4
Эм боох материал	25.1	24.6	-0.5
Бэлэн бүтээгдэхүүн	1.2	0	-1.2
Хангамжийн материал	203.7	27.0	-176.7
Бичиг хэргийн материал	10.4	3.8	-6.6
Аж ахуйн материал	137.8	17.4	-120.4
Сэлбэг хэрэгсэл	5.4	1.7	-3.7
Түлш, шатах тослох материал	2.7	0.9	-1.8
Барилгын засварын материал	20.4	0	-20.4
Хүнсний материал	5.1	0	-5.1
Бусад хангамжийн материал	21.9	3.2	-18.7
Мал амьтад	12.4	5.0	-7.4
Бусад нөөц	10.4	10.4	
Дүн	267.2	67.0	-200.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 67.0 сая төгрөгийн үлдэгдлийн 43.9 хувийг бусад хангамжийн материал эзэлж байгаа бөгөөд тусгай зориулалтын, мал амьтад, тэжээлийн нөөцийн үлдэгдэл гол нөлөөлж байна. Аж ахуйн материалын 63 хувийн Засаг даргын Тамгын газар, 1.1 хувийг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 35.9 хувийг ОНӨААТҮГ, эргэлтийн эмийн сан зэрэг байгууллагууд эзэлж байна.

Бараа материалын бууралт нь Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн орон нутгийн данснаас улсын төсвийн данс руу шилжүүлсэн дүнгээс нөлөөлж буурч байна.

Аудитын илрүүлэлт

- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1¹, 72.4.2², 72.4.4³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6⁴ дахь заалттай нийцээгүй байгаад албан шаардлага хүргүүлэв./Тамгын газар/

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,493.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4,648.2 сая төгрөгөөр буурсан байна.

¹ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

² тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

³ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

⁴ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	5,401.0	1,455.0	-3,946.0
Авто-тээврийн хэрэгсэл	216.9	259.1	42.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	535.6	211.2	-324.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	347.6	135.3	-212.3
Бусад үндсэн хөрөнгө	300.9	163.7	-137.2
Дуусаагүй барилга, байгууламж	244.0	244.0	0
Ном	34.8	0	-34.8
Программ хангамж	2.7	4.9	2.2
Бусад биет бус хөрөнгө	58.2	20.3	-37.9
Дүн	7,141.7	2,493.5	-4,648.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 140.7 сая, акталсан 14.9 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 4,774.1 сая нийт 4,789.0 сая төгрөгөөр хасагдсан байна. Үндсэн хөрөнгийн бууралт нь Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн орон нутгийн данснаас улсын төсвийн данс руу шилжүүлсэн дүнгээс шалтгаалан буурчээ.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 554.5 сая төгрөг болж, өмнөх оноос 376.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	30.7	24.6	-6.1
Татварын өглөг /ТӨҮГ/	6.9	0.1	-6.8
Бусад урьдчилж олсон орлого	80.3	71.3	-9.0
Дүн	117.9	96.0	-21.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 96.0 сая төгрөгийн өр төлбөртэй бөгөөд 95.0 сая төгрөгийг ОНӨААТҮГ, эргэлтийн эмийн сан, 0.1 сая төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн өр төлбөр эзэлж байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,353.6 сая төгрөг болж, өмнөх оноос 4,407.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,512.3	953.1	-1,559.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	300.1	300.1	0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	3,532.3	935.4	-2,596.9
Өмнөх үеийн үр дүн	-6.7	5,160.0	5,153.3
Тайлант үеийн үр дүн	3,539.0	-4,224.6	-7,750.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	416.5	165.0	-251.5
Дүн	6,761.2	2,353.6	-4,407.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгийн дүн 2,353.6 сая төгрөг болж 4,407.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн байгууллагуудыг улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид нэгтгэл хийгдсэнээс засгийн газрын оруулсан капитал 1,559.2 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 251.5 сая, хуримтлагдсан үр дүн 2,596.9 сая нийт 4,582.6 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын залруулга хийж, тайлант үед 4,224.6 сая төгрөгийн үр дүнгүй ажилласан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 04 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлого 145.5 сая төгрөг, татварын бус орлого 7.0 сая нийт 152.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 398.2 сая, татварын бус орлого 7.1 сая нийт 405.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэл 265.7 хувиар биелсэн байна.

Хүснэгт 10 Орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Буурсан/
НИЙТ ОРЛОГО	152.5	405.3	252.7
ТАТВАРЫН ОРЛОГО	145.5	398.2	252.7
Хувь хүний орлогын албан татвар	129.3	147.9	18.6
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар	85.0	99.7	14.7
Үйл ажиллагааны орлого	14.3	24.6	10.3
Хөрөнгийн орлого	25.0	23.6	-1.4
Хөрөнгө борлуулсны орлого	5.0	0.0	-5.0
Хөрөнгийн албан татвар	2.8	80.8	78.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.5	2.3	0.8
Бууны албан татвар	1.3	1.0	-0.3
Малд ногдуулах албан татвар	0.0	77.6	77.6
Бусад татвар (төлбөр, хураамж)	13.5	169.5	156.0
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	1.4	-0.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	11.0	0.8	-10.2
Газрын төлбөр	1.0	1.0	0
Газрын төлбөр	1.0	1.0	0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	159.9	159.9
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	159.9	159.9
Бусад татвар	0.0	6.4	6.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7.0	7.1	0.1
Хүү, торгуулийн орлого	7.0	0.6	-6.4
Нэр заагдаагүй орлого	0	6.5	6.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт дүнгээрээ төлөвлөснөөс 252.7 сая төгрөгөөр биелсэн байна. Байгалийн нөөц ашигласны төлбөр 159.9 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгдөөгүй ан амьтны нөөц ашигласны төлбөр төвлөрсөн нь нөлөөлжээ. Цалин түүнтэй адилтгах орлого 14.7 сая төгрөгөөр давсан нь Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,434.0 сая төгрөг, нийт зардлыг 1,434.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Сумын 2022 оны төрийн үйлчилгээний албан хаагчдын хоорондох цалинг улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор нийт зардлыг 2,424.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,424.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,507.0 сая төгрөгийг урсгал зардалд, 767.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 150.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,050.2 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 167.3 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 43.0 сая нийт 1,260.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,255.5 сая төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	77.8	75.1	2.7	96.5
2	80224- Зөвлөл, хороо, комиссын гишүүд	3.0	3.0	0	100
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	6.3	6.3	0	100
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	3.0	3.0	0	100
5	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	0.8	0.8	0	100
Дүн		90.9	88.2	2.7	
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	358.9	329.8	29.1	91.9
2	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	47.3	47.1	0.2	99.6
3	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	8.9	8.9	0	100
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	25.0	25.0	0	100
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	20.0	20.0	0	100
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	61.1	58.6	2.5	95.9
7	81549- Ахмадын сан	1.3	1.0	0.3	76.9
8	81701- Байгаль хамгаалах ,нөхөн сэргээх зардал	95.0	94.1	0.9	99.1
9	82310- Гамшгаас сэргийлэх сургалт суртчилгаа	2.5	2.4	0.1	96.0
10	82706- Гоц халдварт өвчний голомтыг арилгах	10.0	1.7	8.3	17.0
Дүн		630.0	588.6	41.4	
71802 ерөнхий боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	110.5	110.0	0.5	99.5
2	80112- Нийтлэг үйлчилгээ	30.1	30.1	0	100
Дүн		140.6	140.1	0.5	
71602 эмнэлгийн тусламж үйлчилгээ					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	24.7	21.3	3.4	28
2	80112-нийтлэг үйлчилгээ	5.3	4.5	0.5	85
Дүн		30.0	25.8	4.2	
71702 соёл урлаг					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	66.1	66.0	0.1	99.8
2	80112-нийтлэг үйлчилгээ	4.6	4.6	0	100
3	83201- Ангилагдаагүй бусад зардал	4.5	4.5	0	100
Дүн		75.2	75.2	0.1	
71802 Сургуулийн өмнөх боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	47.1	43.7	3.4	92.8
2	80112-нийтлэг үйлчилгээ	16.7	16.7	0	100
	83201- Ангилагдаагүй бусад зардал	11.9	11.9	0	100
Дүн		75.7	72.3	3.4	

Орон нутгийн хөгжлийн сан хөтөлбөр бичих					
1	83401-итгэлцүүрээр	166.7	113.7	53.0	68.1
2	80918- бусад	0.6	0	0.6	0
3	83405-малын тоо толгойн албан татвар	60.0	41.6	18.4	69.3
4	83406-ОНХС-бусад	10.0	0	10.0	
Дүн		237.3	155.3	82.0	
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих					
1	82611-жижиг дунд үйлдвэрлэл дэмжих	0.5	0.1	0.4	20
2	83111-сүм хөгжүүлэх	139.5	110.0	29.5	78.9
Дүн		140.0	110.1	29.9	

Орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөрт тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлууд дутуу санхүүжигдсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11.5 сая, эхний үлдэгдэл 26.4 нийт 44.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалт 10.3 сая, хангамж, бараа материалын зардалд 1.0 сая, эд хогшил 5.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2.1 сая, нэг удаагийн тэтгэмж 0.5 сая нийт 18.9 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 26.7 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халзан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 15 -аас 2023 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 1,244.5 сая төгрөгийн зардлын 2 хувь буюу 24.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Халзан сумын Засаг даргын тухай хуульд хамаарах зүйл заалт бүрээр горим сорил хэрэгжүүлсэн. Халзан сумын Засаг даргын Тамгын газар нь цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 9,149.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁵ дахь заалтыг зөрчсөнд албан шаардлага өгөв.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулаагүйд албан шаардлага хүргүүлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Халзан сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

⁵ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	0	2	0	75
Нийт дүн	3	0	2	0	75

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50.6 сая төгрөгийн зөрчил⁶ илэрснээс, 50.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Орлоготой холбоотой асуудал

5.1.1 Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 50.6 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнө жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁶ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
/сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	2	9,149.0			2	9,149.8						
Дүн	2	9,149.0			2	9,149.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
/сая төгрөгөөр/										
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Засаг даргын тамгын газар	1	0			1	0				
Дүн	1	0			1	0				